

<https://doi.org/10.69561/mjac.v26i51.5242>

Article | Fasc.5

Говийн бүсэд судлагдсан монгол булшны хэрэглэгдэхүүнд хийсэн дүн шинжилгээ

Очирпүрэвийн Мөнхцэцэг 

Соёл урлагийн их сургуулийн Эрдэм шинжилгээ ахисан
түвшний хөтөлбөрийн алба, Улаанбаатар, Монгол Улс
✉ munkhtsetseg1111@gmail.com

Хураангуй: Энэхүү өгүүллээр Говийн бүсэд хийсэн монгол булшны судалгааны тойм, малтлагаар илэрсэн эд өлгийн зүйлсийн талаарх мэдээллийг нэгтгэн үзүүлэв. Ингэснээр Говийн бүсэд судлагдсан монгол булшны хэрэглэгдэхүүнийг судалгааны эргэлтэд оруулахад бусад судлаачдад тодорхой хэмжээний дөхөм үзүүлэх юм. Дундад үеийн монголчуудын оршуулгын зан үйлийн онцлог энэ бүс нутагт хэрхэн илэрч байгааг судалгааны бүтээлүүдэд дүн шинжилгээ хийж тодруулах оролдлого хийсэн болно. Бидний судалгаанд монгол орны нутагт археологийн судалгаа хийгдэх болсон цагаас 2020 он хүртэл Говийн бүсэд судлагдсан 40 дурсгалт газрын 94 булшны малтлагын хэрэглэгдэхүүний судлагдсан байдлын тойм болон зан үйлд холбогдох зарим олдворыг авч үзсэн болно. Эдгээрийн дийлэнх нь уул уурхай олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд хийгдсэн авран хамгаалах судалгааны үр дүнд судлагдсан байна. Говийн бүс нутаг эдийн засгийн эргэлтэд эрчимтэй хамрагдах болсноор олон үеийн дурсгалт газрууд шинээр илэрч, түүний дотор дундад зууны үеийн монгол булшны судалгаа урьд өмнөхөөс хэд дахин хурдтай хийгдэх болсон байна. Үүний үр дүнд олдворууд ихээр хуримтлагдах болсон нь биднийг ийнхүү судалгааны мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийхэд хүргэсэн билээ. Мөн олдвороос зан үйлийг тодруулан судалснаар эртний монголчуудын нийгэм, зан заншил, худалдаа, үйлдвэрлэл, оршуулгын зан үйлийг тодорхойлох боломжтой болох юм.

Түлхүүр үгс: *говийн бүсийн онцлог, монгол булшны судалгааны тойм, зан үйл, эд өлгийн зүйлс, авран хамгаалах судалгаа*

An Analysis of Medieval Tombs Archaeological Finds in the Gobi Region

Munkhtsetseg Ochirpurev 

Department of Research and Graduate Programs, Mongolian National
University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia
✉ munkhtsetseg1111@gmail.com

Abstract: This article presents a synthesis of previous studies on medieval tombs conducted in the Gobi region and compiles information on artifacts recovered from archaeological excavations. By systematizing these materials, the study aims to facilitate further research by making the archaeological evidence associated with mongolian medieval tombs in the Gobi region more accessible to scholars. The paper also attempts to clarify how the distinctive features of medieval tombs practices are manifested in this region through an analytical review of existing research. The present study incorporates materials from the excavation of 94 burials at 40 archaeological sites in the Gobi region, investigated from the beginning of archaeological research in Mongolia up to 2020. The majority of these burials were studied as part of rescue excavations conducted within areas licensed for mining activities. As the Gobi region has become increasingly integrated into economic development, numerous archaeological sites from different historical periods have been newly identified. Consequently, research on medieval tombs has progressed at a significantly accelerated pace compared to earlier periods. The rapid accumulation of archaeological finds has therefore necessitated the compilation and analytical examination of available research data. Furthermore, by examining ritual practices inferred from the archaeological artifacts, it becomes possible to more precisely reconstruct the social structure, customs, trade, production activities, and funerary practices of the ancient Mongols.

Keywords: *characteristics of the Gobi region, overview of mongolian tombs studies, ritual practices, artifacts, rescue archaeology*

Оршил

Археологийн малтлага, судалгаагаар илэрсэн эд өлгийн зүйлс, тэдгээрийн бүтэц, хэрэглээ, байршил зэрэг харилцан уялдаатай цогц мэдээлэл нь тухайн түүхэн үед оршин байсан хүмүүсийн амьдралын хэв маяг, нийгмийн зохион байгуулалт, үнэт зүйл, урлаг, шашин шүтлэг, аж ахуй зэргийг тодорхойлох боломжтой соёлын чухал баримт болдог. Аливаа ард түмний өнгөрсөн түүхэн үйл явдал, онцлог, соёлыг бичмэл эх сурвалж, эд өлгийн дурсгал буюу археологийн олдвор хийгээд ард түмний үеэс үед дамжин хэрэглэж ирсэн эд зүйлс, зан заншил харуулж болдог. Археологийн олдворууд нь тухайн цагийн монголчуудын оршуулгын зан үйл, байгаль ертөнцийн тухай мэдлэг, төсөөлөл, итгэл үнэмшлийн тогтолцоо, ахуй байдал, хөдөлмөрийн хуваарь, анги давхраажилт, соёлын гадаад харилцаа, уламжлалт урлахуй ухаан буюу мужаан, дархан, уран үйл урлалын хөгжлийн түвшин, тэдгээрийн орон нутгийн ялгаа, онцлогийг тодруулахад чухал ач холбогдолтой болох юм. Говийн бүс нь Монгол орны өмнөд хэсэгт орших, байгаль, газар зүй, цаг уур, биологийн төрөл зүйл, соёл, археологи, эдийн засгийн онцлог бүхий өвөрмөц бүс нутаг юм. “Өмнө нь судлаачид говь нутгийг өнөөгийн байгаль орчин, цаг агаарын байдалд тулгуурлан археологийн дурсгал харьцангуй бага хэмээн үзэж, тодорхой судалгаа хийлгүй олон жил өнгөрсөн юм. Гэхдээ сүүлийн 20 жилийн хугацаанд хийгдсэн судалгаагаар энэ бүс нутаг хуучин чулуун зэвсгийн үеэс XIX зуунд хамаарагдах олон мянган дурсгал оршин байгааг илрүүлэн олж, түүнээс заримыг сонгон малтлага судалгааны ажлыг хийгээд байна” (Амартүвшин,

Батзориг, Батдалай 2019, 9). Энэ бүс нутгаас олдсон олдвороос зан үйлийг түлхүү тодруулахыг зорьсон бөгөөд инэгснээр эртний монголчуудын нийгэм, зан заншил, худалдаа, үйлдвэрлэл, оршуулгын зан үйлийг тодруулах ач холбогдолтой.

Судалгааны арга зүй

Дундад зууны үеийн 1960-2020 оны хооронд малтсан булшны мэдээллийг эх сурвалжийн хэрэглэгдэхүүнд тулгуурлан задлан шинжлэх, Говийн бүсэд хамрах малтлагын мэдээллийг нэгтгэн дүгнэв.

Судалгааны үр дүн

Монгол орны гадаргын онцлогоос хамаараад хэд хэдэн бүс бүслүүр болгон хуваадаг бөгөөд Говийн бүсэд газар нутгийн онцлог, ижил төстэй байдлаар Дорноговийн урдуур нутаг, Өмнөговь, Өвөрхангайн өмнөд хэсгийн нутгийг Говийн бүсэд хамруулан судлагдсан байдлыг тоймлов. Энэ бүс нутагт 1960–аад оноос эрчимжих болсон чулуун зэвсэг судлалын ажлын цар хүрээнд бусад төрлийн дурсгалыг судлах болсон бөгөөд үүний дотор монгол булш ч хамрагдах болсны анхны тохиолдол нь Монгол-Зөвлөлтийн хамтарсан Чулуун зэвсгийн үе судлах ангийн Өмнөговь аймгийн Манлай сумын нутаг Хар Аргалант ууланд хийсэн судалгаа байжээ. Энэ талаар В.В.Волков 1962 оны БНМАУ-ын ШУА-ийн мэдээ сэтгүүлийн 4 дугаарт “Эртний монгол булш” нэртэй өгүүлэл нийтэлж байжээ.

Бидний цуглуулсан эх сурвалжийн хэрэглэгдэхүүнээс үзэхэд Говийн бүсэд 2008 он хүртэл монгол булшны судалгаа туйлын удаашралтай, заримдаа зогсолтын байдалтай байсан бол түүнээс хойш үйлдвэрлэл, аж ахуйн зориулалтаар олгосон талбай, уул уурхай ашиглалтын талбайнуудад авран хамгаалах чиглэлийн судалгаа эрчимтэй хийгдэх болсноор монгол булшны судалгаа тасралтгүй өссөн дүр зураг харагдаж байна. Ингэж Говийн бүсэд идэвхжсэн “Авран хамгаалах малтлага нь нэг дор харьцангуй олон тооны булш хамруулдгаараа онцлогтой бөгөөд тухайн орон нутгийн оршуулгын соёлын нийтлэг талыг тодруулах, хүн ам зүйн судалгаа хийх зэрэг олон талын давуу талтай” (Өлзийбаяр, Мөнхцэцэг 2025) билээ.

2008 онд Д.Түмэн нарын удирдсан хээрийн шинжилгээний анги South Gobi Sands компанийн Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Цагаан толгойн ашиглалтын талбай, Гүн хармагтай, Угалз, Дэл хад, Их өвгөн уул, Шар цохио, Уушиг, Шар таг зэрэг газарт авран хамгаалах судалгаа явуулж, дундад зууны үед хамаарах монгол булш 20 гаруйг малтан судалжээ (Түмэн, Наваан, Эрдэнэ 2008). Эдгээрээс зан үйлд холбогдох хойлгын малын яс, төмөр зэв, хүрэл толь, үйсний үлдэгдэл, гоёл чимэглэлийн зүйлээс гадна эсгий дэвссэн байх ул мөр, дээлийн үлдэгдэл олдсонийг тэмдэглэсэн байна. Мөн 2010 онд МУИС-ийн НШУС-ийн Археологи-Антроплогийн тэнхимийн хээрийн шинжилгээний анги Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дахь “SGS” ХХК-ийн ашиглалтын талбайд Банзарт хайрханы орчимд, Эрдэнэхайрханд, Важигийн Хар ууланд, Ганзагадын талбайд монгол булш малтсан (Түмэн 2008). Эдгээр булшинд илэрсэн нийтлэг шинж нь чулуун дараастай байгууламж, оршуулгын чиглэл зүүн болон зүүн хойд зүг давамгайлах, талийгаачийг хувцастай оршуулж эсгий дэвсэх, мөн малын яс (дал, нугалам, шаант) дагалдуулах зан үйл байв. Малын яс, ялангуяа дал, нугаламыг хүний гар, цээж, ууц орчимд зориуд байрлуулсан нь монголчуудын оршуулгын

зан үйлийн эртний нэгэн хэлбэр бөгөөд мал аж ахуйд суурилсан ахуй, тахилгын уламжлалтай хамааралтай.

2008 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Б.Гүнчинсүрэн, Ч.Амартүвшин нарын бүрэлдэхүүнтэй хээрийн шинжилгээний анги Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших “Энержи Ресурс” ХХК-ны “Ухаа худаг” ашиглалтын талбайд 2008 оны 6, 10, 11 дүгээр сард, 2010-2011 онд “Ухаа худаг” нүүрсний уурхай орчимд монгол булшнууд малтан судалжээ. 2008 онд малтсан дурсгалууд нь говийн намхан толгодын зүүн, зүүн хойд болон хойд биед орших бөгөөд нийт 29 булшны 10 булшнаас хүрэл зэвсгийн үеэс дундад зууны үед хамаарагдах оршуулга болон эд өлгийн зүйлс, үлдсэн 19 дурсгал нь тахил тайлгын шинж чанартай зүйлс байжээ. Эдгээр булшны 6 нь XII-XIV зууны үед хамаарагдах (Амартүвшин, Гүнчинсүрэн, Ерөөл-Эрдэнэ ба бус.2008) ба уг үр дүнгээ Археологи судлал сэтгүүлд хэвлүүлсэн байдаг. Энэ хэсгийн булшинд нийтлэг ажиглагдах шинж нь модон хашлагатай, австай оршуулга ба модон авс, хашлага бүхий бүтэцтэйгээр оршуулж байсны илрэл байна. Мөн ихэнх булш баруун хойш чиглэлтэй байгаа нь тухайн бүс нутгийн газар зүйн онцлогийг илтгэж болно.

2010-2011 онд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших “Энержи Ресурс” ХХК-ийн “Ухаа худаг” нүүрсний уурхай, Ханбогд сумын нутаг дахь “Оюу толгой” ХХК-ийн ашиглалтын талбайд дундад зууны үед холбогдох 18 чулуун дарааст булш малтан судалсан ба бүгд говийн намхан уул, толгойн урд энгэр бэлээр ганц нэгээрээ сондгой байдалтай тохиолдож байна (Амартүвшин, Галдан, Батдалай ба бус. 2012).

2009 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судлаачид Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутагт орших “Хангад Эксплорейшн” ХХК-ийн ашиглалтын талбайд монгол булш малтсан тухай Ч.Амартүвшин, Ц.Амгалантөгс, Г.Галдан, Б.Жаргалан нар “Нүүдэлчдийн өв” судлал сэтгүүлийн 2010 оны 10 дугаарт “Барууннаранд хийсэн археологийн малтлага судалгааны урьдчилсан үр дүн” өгүүлэлдээ нийтэлжээ. Дэлгэрүүлбэл, дундад зууны үед холбогдох 4 булшны гадаад дотоод бүтцийн мэдээллийг багтаасан ба үйсэн хоромсого, төмөр хутга, шавар ваарны хэсгүүд, төмөр суурьтай хүрэл эдлэл болон бусад олдворууд гарсныг дэлгэрүүлэн тэмдэглэн үлдээсэн байдаг (Амартүвшин, Амгалантөгс, Галдан, Жаргалан 2010, 28-56).

2005-2014 оны хугацаанд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судалгааны анги Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт авран хамгаалах малтлага судалгаа хийж, Будаагийн улаан, Талын хар, Хар Дэлийн толгод, Түймэрт, Хүрэн дэл, Тоонотын ар орчим, Хар толгой, Ясан хашаат, Хүрэн толгойн хоёр модны орчим, Ханангийн тойром, Маанийн задгай, Сондуулын задгай, 2012 оны хавар мөн Ханбогд сумын нутагт Бага Гүн ухаа, Цагаан овоо, Зэлтийн гол, Хүйс толгой, Хөх хадны бууцын орчимд гээд газруудад 23 чулуун дарааст монгол булш, 3 хадны оршуулга малтан судалжээ. 2013 онд Цогтцэций сумын нутаг дахь “Эрдэнэс таван толгой” ХК-ийн үйл ажиллагаа явуулж буй талбайд тус тус монгол булш малтсан дэлгэрэнгүй мэдээллээ “Ханбогдын археологийн дурсгал” (2019) нэгэн сэдэвт бүтээлд (Амартүвшин, Батзориг, Батдалай 2019, 124-146) хэвлүүлснээс гадна, Б.Батдалай “X-XVII зууны монгол булш, оршуулгын судалгаа (Монгол

улсад малтсан хэрэглэгдэхүүнээр)” (2024) Түүхийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилон бичсэн бүтээлдээ оруулсан байна. Энэ газар нутагт модон авс, хашлагатай оршуулга болон авсгүй оршуулгын төрлөөс гадна хөмөглөн амсрыг банз, нарийн модоор тагласан оршуулга мөн тохиолдож байна. Малын яс, тэр дундаа богийн дал, шагайт чөмөг, нуруу, ууц тогтмол дагалдуулсан нь дээр дурдсанчлан, мал аж ахуй эрхэлдэг ард түмний тодорхой нэгэн зан үйл байсныг бүрнээ илтгэнэ. Эдгээрийг хүний мөр, гар, хөлний орчимд тодорхой чиглэлтэй, босоо, хэвтээ, хамтад нь, дангаар байрлуулахаас гадна зэвсэг, ангийн болон морин хэрэглэлийн эдлэл, хүрэл толь, сүүжин ээмэг, зоос, сувс, ээрүүлийн дугуй, гоёлын чимэглэл зэрэг ахуй, гоёлын шинжтэй эдлэл дагуулж байгаа нь тухай бүр утга бэлгэдэлтэй байх нь дамжиггүй бөгөөд цаашид нарийвчлан судлах шаардлагатай байна.

2012 онд Ч.Амартүвшин, Б.Батдалай нар Цогтцэций сумын нутагт орших “Оюут улаан” ХХК-ийн Хармагтай ашиглалтын талбайд 1 булш, 2016 оны хавар ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн судалгааны баг Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших “Жавхлант Орд” ХХК-ийн дэд бүтцийн талбайд авран хамгаалах малтлага судалгааны ажил явуулахдаа Улаан худаг, 2016 оны 6-р сард МУИС-ийн хээрийн шинжилгээний анги Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших “Монгол Чадал Энержи” ХХК-ийн ашиглалтын талбайд Зангат уулын орчим хэмээх газар малтсан монгол булшны мэдээллийг доктор Б.Батдалай мөн өөрийн диссертацдаа дэлгэрүүлэн бичсэн байна. Тэрээр монгол орны нийт нутагт 186 газарт нийт 800 гаран чулуун дарааст булш малтаад байгаа бөгөөд үүнээс 2007-2020 оны хооронд л гэхэд 93 дурсгалт газар 530 чулуун дарааст булш малтсаны 80%-ийг авран хамгаалах судалгааны хүрээнд судалсан (Батдалай 2024, 31) гэж дүгнэжээ.

Судалгааны тайлан, өгүүлэл, нэг сэдэвт бүтээлүүдэд түшиглэн гаргасан судалгааны тоймоос гадна соёлын илэрхийлэл болох чиглэл, бүтэц, дагалдуулсан эд өлгийн зүйлс болон хойлгын малын ясны мэдээллийг мөн тодруулахыг зорилоо. Энэ нутагт нийт 40 газрын 94 булш хамрагдаж байгаа ба дийлэнх нь авран хамгаалах ажлын хүрээнд малтсан булш байна. Говийн бүс нутагт булш нь нэг хоёроороо түлхүү тохиолддог, бөөгнөрөл нь цөөн тоогоор байдаг онцлогтой бүс нутаг юм. Энэхүү бүс нутгийн нийт булшны 89,4%-ийнх нь булшны гүн мэдэгдэж байгааг харахад гүний хувьд харьцангуй гүнд буюу 100 см-ээс гүнд тавьсан булш 63,1%, 100-аас дотогш см-т илэрсэн булш 36,9%-ийг эзэлж байна. Эдгээрийн дундаж гүн 107,94 см ажээ.

Монгол булшны хувьд хүнээ хандуулсан чиглэл дийлэнхдээ баруун хойшоо, хойшоо, зүүн хойшоо гэсэн чиглэлтэй байдгийн ижил говийн бүсэд малтсан булшны хүнээ хандуулсан чиглэл тодорхой булш нийт булшны 81,9% байгаагаас баруун хойшоо 61,1% нь, хойшоо чиглэлтэй 24,7%, зүүн хойшоо чиглэлтэй 9% нь буюу зүүн хойшоо чиглэлтэй байна. Харин баруун чиглэлтэй 3,9%, зүүн чиглэлтэй 1,3% байгаагаас үзвэл дийлэнх булшийг баруун хойшоо чиглүүлсэн нь тодорхой байна. Эртний булшнууд зарим нь авс, модон хашлага зэрэг модон байгууламжтай байхад зарим нь шууд тавьсан, мөн хажуу тийш хөмгөлөн оршуулсан зэрэг олон янз байдаг.

“Нутаглуулах газар сонгож дагуулах эд агуурс, оршуулгын нүхийг бэлтгэсний дараа оршуулга үйлдэх үйл явц тодорхой дарааллаар явагдаж байсныг археологийн баримтаас харж болно... ..Оршуулгын ёслол малын махан хойлгыг зохих байранд нь тавьснаар эхэлдэг байсан бололтой. Үүнийг богийн шагайт чөмөг, дал, нурууны ясны булшнаас илрэх анхны байрлал илтгэнэ. Тухайлбал, богийн нурууг хүний нурууны доор (австай тохиолдолд нурууны чигт авсны доороос) тусгай жижиг хонхорт, дал, шагайт чөмгийг оршуулгын нүхний аль нэг (баруун хойд, зүүн хойд, баруун урд, зүүн урд) талд хана налуулсан байдалтай илэрдэг. Эдгээрийг гол төлөв амьд малд байх анатомийн байрлалаар тавьдаг байна. Ийнхүү хойлгын махыг байрлуулсны дараа нүхэнд шарилыг тавьж бусад эд хэрэглэлийг мөн тогтсон ёсоор дагуулдаг байжээ. Үүнийг зарим бүрэн хадгалагдан үлдсэн булшны хэрэглэгдэхүүнээс харж болно. Гэсэн хэдий ч энэ нь зарим тохиолдолд эсрэгээр үйлдэгдэж байсныг (Батдалай 2024, 84-85) үгүйсгэх аргагүй.

Эд өлгийн зүйлс нь нийгмийн байр суурь, соёлын харилцан нөлөө, урлаг, соёлын илэрхийллийн чухал хэрэглэгдэхүүн болох чадамжтай байдаг. Малтлагаар илэрсэн олдворыг ерөнхийлөн дараах байдлаар тоймлон ангилж болохоор байна. Үүнд,

- Зан үйлийн холбогдолтой зүйлс
- Зэр зэвсгийн зүйлс
- Гоёл чимэглэл, хувцас эдлэл
- Ахуйн хэрэглэл
- Морины тоног хэрэглэл

Зан үйлийн холбогдолтой зүйлс. Монгол оршуулгын зан үйлийн нэгэн чухал хэлбэр нь булшинд хойлоглох малын яс билээ. “Монгол булшнаас олдсон малын махан хойлгоны дотор хонины мах, тэр дундаа шагай чөмөг зонхилж байгаа нь монгол угсаатны бэлгэдэл зүйн сэтгэлгээн дэх үржлийн болон сүнс эргэж төрөх тухай үзэл төсөөлөлтэй нягт холбоотой ажээ. Монголчуудын шагай чөмөг эрхэмлэх ёс ба шагайгаар наадах олон зуун жилийн уламжлалаас үзэхэд, дундад зууны нүүдэлчдийн булшинд шагай чөмөг дагалдуулан хийдэг нь талийгаач нөгөө ертөнцөд очоод хонь, ямаа, адуу, үхэр, тэмээн сүрэгтэй, мөр бүтэн, гэдэс цатгалан явахыг ерөөсөн бэлгэдлийн утгатай байсан бололтой” (Амартүвшин, Батзориг, Батдалай 2019, 129). “Тэгэхдээ булш оршуулганд шагай чөмгийг хаа хамаагүй тавих биш, тогтсон нэгэн байрлалаар босгож тавьдаг (Тавилт), оршуулгын зан үйлийн ийм хэлбэр монгол угсаатны голомт нутагт тархсан байдал (Тархац), өөр бусад ямар ч ард түмний дунд биш, харин гагцхүү хожмын монголчуудын дотор өнөөг хүртэл амьд хэвээр байгаа шагай чөмөг эрхэмлэх зан үйл (Уламжлал) зэргийг нэгтгэн дүгнэж үзвэл энэ заншил дундад эртний монгол угсаатны оршуулгын соёлын онцлогийг бүрэн төлөөлж чадах нэгэн чухал шинж тэмдэг мөн байна” (Эрдэнэбат 2010, 260-261). Бидний судлан буй бүс нутагт малтсан булшнаас богийн шагайт чөмөг шагайтай, шагайгүй, хоёр болон гурван үе нурууны яс, дал дийлэнх булшинд илэрсэн бол, гөрөөсний бололтой жижиг яс, бод малын тагалцгийн ясны хугархайн хэсгүүд, бод, бог малын цөөн тооны хугархай яс, богийн 1 ш хавирганы хугархай, адууны хавирганы яс цөөн тоогоор, бодын туурайн яс, бог малын хаа, бүтэн ямааны яс зэрэг олджээ. Богийн шагайт чөмгийн

олдсон байрлалыг жишээлэн авч үзвэл, авсны гадна толгой талд богийн шагайт чөмгийг шагайтай талыг нь дээш харуулан, зүүн гарын тохой орчимд богийн шагайт чөмөг хана түшүүлэн босгон, баруун хананаас хагас налуу байдалтайгаар босгон тавьсан богийн шагайт чөмөг, хашлаганы толгой хэсэгт богийн шагайт чөмөг босоо байдалтайгаар, баруун хөлийн доод талаас босоо байдалтай тавьсан бог малын шагайт чөмөг, баруун хөлийн доод талаас босоо байдалтай тавьсан бог малын шагайт чөмөг мөн аарцгийн ясны зүүн талаас бас нэг шагайт чөмөг зэрэг тодорхойлолтоос харахад, толгойн хэсэг, их биеийн хэсэг, хөлний хэсэг, тавхайн хэсгээс олдсон байгаа ба энэ нь тухай бүр тодорхой бэлгэдэл, зан үйлтэй холбоотой байх магадлалтайгаас гадна хүн, мэрэгч амьтдын нөлөөгөөр тодорхой орон зайд зөөгдсөн, хөдөлсөн байж болзошгүй юм.

Харин бог малын нурууны ясны хувьд дийлэнх тохиолдолд хоёр болон гурван үеэр хүнийхээ нурууны харалдаа, австай бол авсны доор газар хонхойлон оруулж тавьсан байдалтай байгаа ч, нэг үеэр, өөр байрлалаар илрэх тохиолдол мөн гарсан байна. Т.Түвшинжаргал “Дундад эртний үеийн булшинд бог малын нуруу дагалдуулах зан үйлийг мөшгөх нь” (2012) өгүүлэлдээ булшинд бог малын нуруу дагалдуулах зан үйлийн талаар

1. Алунгоа хатны ариун нуруунаас төрсөн гэх гурван хүүг бэлгэдсэн байж болох юм. Нуруу дагалдуулсан оршуулга нь гурван хүүгийн овгийг нэрлэх Нирун овогтонд хамаарах хүмүүсийн оршуулга байж болох бөгөөд гурван нуруу нь тухайн овгийн дээд язгуур угсаатан болохыг илэрхийлсэн билэгдэл байж болох,

2. ...монгол нутаг дахь эртний түүхийн бүхий л цаг хугацаанд оршиж ирсэн бөөгийн шашинтай холбогдолтой зан үйл байж болох... бөөгийн онгодын унаа гэж үздэг дээрх амьтдыг билэгдэн илэрхийлсэн байж болох (Түвшинжаргал 2012, 139-140) хэмээн таамаг дэвшүүлжээ.

Далны хувьд энэ бүс нутгаас харьцангуй бага олдсон байгаагаас гадна байрлал мөн л олон янз, толгой талыг босгосон, хүний толгойн дагуу чиглүүлсэн зэрэг байрлалтай байна. Өөр малын болон зэрлэг амьтны яс цөөнгүй олохоос гадна энэ хэсгийн бүсэд Өмнөговь аймгийн Номгон сумын Гүн хармагтайн булшнаас бүтэн ямааны яс олджээ.

Монголчуудын оршуулгын соёлын бас нэгэн илэрхийлэгч бол эрэгтэй, эмэгтэй хүнд дагалдуулан тавих олдворын төрөл юм. Эрэгтэй хүний оршуулганд зэр зэвсэг, адуу малын тоног хэрэгсэл, эмэгтэй хүний оршуулганд хувцас, гоо сайхан, ахуйн хэрэгсэл дагалдуулах нь нэгэнт тогтсон хэлбэр болно.

Зэр зэвсгийн зүйлс. Эрт үеэс монголчуудын ангийн болон байлдааны гол зэвсэг нь нум сум байсан бөгөөд монгол эрчүүдийн сүр хүчний бас нэгэн илэрхийлэл байжээ. Иймдээ ч тухайн хүний булшинд эдэлж хэрэглэж байсан эд зүйлсийг дагуулдаг байсны дагуу эрэгтэй хүний булшнаас нумын үлдэгдэл, сумын зэв, сум агуулах сав буюу саадгийн үлдэгдэл болох үйсэн хэсгүүд илрэх нь элбэг. “... Саадгийг оршуулганд дагалдуулан тавихдаа дотор нь сум дүрж тавьдаг бөгөөд сумны мөс, өд зэрэг органик бүрдэл хэсгүүд нь газрын хөрсөнд шингэж малтлагаас төмөр зэв нь илэрч олддог (Амартүвшин, Батзориг, Батдалай 2019, 131) ба саадгийг булшинд дагуулан тавихдаа хүний хажуу талд гар болон хөлийн тушаа оршуулгын нүхний хананд тулгаж, хүний гар, хөлийн дээр тавина. Ингэхдээ ямагт амсрыг

толгой талруу буюу хойд зүгт хандуулан тавьдаг (Батдалай 2024, 152). Доктор У.Эрдэнэбат "...саадгийг тухайн хүний наснаас хамаарч хаана дагалдуулан тавихыг тогтоодог байсан бололтой. Монголчууд саадгийг агсарга бүснээс зүүж хэрэглэдэг байсан бөгөөд Хүрэн дэлийн булшнаас илэрсэн идэр насны хүний бүсэлхий орчимд байрлуулсан байгаа нь тухайн хүн саадгийг ид хэрэглэх насан дээрээ өөд болсон, харин Хар толгойн хөгшин настай хүний хөл дагуу байрлуулсан нь уг хүн нас өндөр болж саадаг хэрэглэхээ больсон хэмээн үзэж хөлд тавьсан байж болох юм" (Эрдэнэбат 2010) хэмээн Дундговь аймгийн Хүрэн дэлийн, Талын харын, Хар толгойн булшнаас олдсон саадагнуудад үндэслэн дүгнэжээ. Дээрх бүс нутагт хамааруулсан булшнаас зэр зэвсгийн зүйлд хамаарах олдворыг түүж, нэгтгэж үзвэл, төмөр зэв 36 ширхэг, үүнээс 2-4 ширхгээр болон 1 ширхгээр, саадагны үйсэн үлдэц 13 ширхэг, модон иштэй, ширэн бүрээстэй нум 1 ширхэг олджээ. Жишээ дурдвал, 1960 онд Монгол-Зөвлөлтийн хамтарсан Чулуун зэвсгийн үе судлах анги Өмнөговь аймгийн Манлай сумын нутаг Хар Аргалант ууланд малтсан булшнаас хүний ясны баруун гар талд ширэн хоромсоготой, нумын хөвчийг үсийг нь сайн хусаж арилгаагүй, нойтон арьсаар мушгиж хийсэн нимгэн арьсаар оёж бүрсэн наамал модон нум, үйсээр хийсэн нарийвтар гүнзгий саадганд шилбэтэй дүгрэг ба шовх үзүүртэй төмөр зэвтэй хэдэн сум, 2008 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн хээрийн шинжилгээний анги Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших "Ухаа худаг" ашиглалтын талбайд малтсан ЭБД 70 дугаар булшнаас төмөр зэв, сүйхэлжин /ромбо/ хэлбэртэй төмөр зэв олджээ. ЭБД 82 дугаар булшнаас бүтэн үйсэн ховдыг төмөр зэвний хамт дагалдуулан тавьсан нь монгол булшны зан үйлийн салшгүй нэгэн хэсэг юм.

Гоёл чимэглэл, хувцас эдлэлийн олдворууд. Малтлага судалгаагаар илэрсэн гоёл чимэглэл, хувцас, эд өлгийн зүйлс нь мөн л тухайн цаг үеийн нийгмийн бүтэц, шашин шүтлэг, гоо зүйн үнэлэмж, зан үйлийн ойлголтыг илтгэх чухал соёлын мэдээлэл агуулдаг. Монгол булшнаас нас хүйс хамааралгүй элбэг олддог олдвор бол ээмэг байна. Ээмэг нь алт, мөнгө, хүрэл зэрэг дан металаар хийгдэхээс гадна оюу сувд зэрэг эрдэнийн чулуу шигтгэж чимэглэдэг, хэлбэрийн хувьд сүүжин болон өөр хэлбэрээр олддог байна. Сүүжин ээмгийг Ч.Амартүвшин, Л.Ишцэрэн, Б.Бадма-Оюу нарын судлаачид "НТӨ XVI-XV зууны хүрэл зэвсгийн үеэс эхлэн үзэгдэж эхэлсэн "сүүжин" маягийн ээмэг нь НТӨ III-НТ II зууны хүннү нараар дамжин тодорхой хугацааны дараа XII-XIV зууны монголчууд, цаашлаад өнөө үе хүртэл уламжлагдан иржээ хэмээн үзэж болохоор байна" (Амартүвшин, Ишцэрэн, Бадма-Оюу 2017, 275) гэж үзсэн байдаг. "Монголчууд байгалийн үнэт чулууг засаж, голоор нүхлэн хувцас хэрэглэлээ чимэглэж байсныг харуулах чулуун сувс, зүүлт оршуулганаас цөөнгүй илэрдэг билээ. Мөн шилийг хайлуулж өнгө алаглуулан янз бүрийн хэмжээтэйгээр хийсэн сувсыг ашиглаж байсан нь мэдэгддэг. Шил, чулуун сувсыг оршуулганд дагалдуулахдаа хүйс харгалзахгүйгээр тавьдаг. Энэ нь оршуулганд зориулан тавьж буй биш тухайн хүний хувцас хэрэглэлд байсан эдлэлийн үлдэгдэл болов уу" (Амартүвшин, Батзориг, Батдалай 2019, 132). Ээмэг, зүүлт, сувс зэрэг нь тухайн хүний нийгмийн байр суурь, гэр бүлийн байдал, насны онцлогийг илтгэнэ гэж доктор У.Эрдэнэбат онцолсон байдаг.

Дундад зууны булшны нэгэн таних тэмдэг, эмэгтэй хүний оршуулгаас хамгийн түгээмэл олддог олдворын нэг бол богтаг малгай юм. Богтаг малгай нь эмэгтэйчүүдийн гоёл бөгөөд орой нь дээш өргөгдсөн, тэнгэр өөд хандсан хэлбэртэй, эмэгтэйчүүдийн язгуур гарал, зэрэг зиндааг илэрхийлэх нэгэн төрлийн малгай юм. Монгол хэлний их тайлбар тольд “Богтлогдсон эмэгтэй ба сурвалжит эмэгтэйн өмсөх тусгай хэлбэртэй малгай, нөхөрт гарсан эмэгтэйчүүд үсээ тусгайлан янзалж өмсдөг нэг тохой орчим өндөртэй гоёлын малгай; Сурвалжит эмэгтэйн өмсөх маш өндөр орой бүхий гоёлын малгай” хэмээн тайлбарлан бичжээ. Иймээс богтаг малгайгаар эмэгтэй хүний, тэр дундаа эхнэр хүний болон сурвалжит эмэгтэйн булш хэмээн тодорхойлох боломжтой байна. Богтаг малгайг бусад эд зүйлсийн адил булшинд дагуулан тавихдаа тодорхой тогтсон байрлалаар тавих ба “ихэвчлэн малгайн оройн бортого хэлбэрийн үйсэн хэсгийг таслан дагуулна. Богтагны бүрдэл хэсэг болох а) цог чимэг, б) нүүрэн талын хүрэл хонгио, в) нүүрэн талын хөөмөг чимэг, г) шанааны унжлага буюу сүйх чимэг зэрэг олон жижиг хэсгүүд богтаг малгайг төлөөлнө. Богтаг малгайг булшинд дагуулахдаа ихэвчлэн хүний бүсэлхийнээс дээш цээж, толгой орчимд тавих бөгөөд хөл талд тавих нь бий” (Батдалай 2024, 124). Малгайг ерөөс хоёр хэсэг салгаж тавих бөгөөд маш цөөн тохиолдолд толгойд углах хэсгийг өмсгөөтэй хэвээр нь үлдээж, ихэнх тохиолдолд түүнээс дээших орой руугаа өргөссөн нэг тохой орчим урт бортогыг гол төлөв шарилын толгойн баруун зүүн талд, эсвэл элэг, цээж, аарцган дээр, үгүй бол хөлийн шилбэ, өвдөгний орчим тавьж дагалдуулдаг оршуулгын зан үйлийн анхаарууштай баримт ажиглагдаж байна. Зан үйлийн энэ онцлог нь он цаг, овог аймгийн ялгааг харуулж болохоос гадна малгайг хоёр салгаж тавьдаг заншил, тухайн үеийн монголчуудын сүсэг бишрэл, тухайлбал, сүнс гарах болон хойд насны тухай ойлголт төсөөлөлтэй нягт холбоотой ажээ (Эрдэнэбат 2010, 257).

Мөн дээл хувцас, торго, бөс эдлэлийн үлдэгдэл нь өмсгөсөн байдалтай болон дэрлүүлсэн, дагуулсан байх нь бий. Торго, даавуу, бөс эдлэлийн үлдэгдлээс тухайн цагийн Хятад, Төв азийн соёлын нөлөөний илрэл гадаад худалдаа харилцааг мөн судлах боломжтой. Мөн хүнийхээ дор эсгий дэвсдэг ул мөр Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Цагаан толгойн ашиглалтын талбайн булшнаас авсны ёроолд эсгий боллолтой зүйл дэвссэн, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Эрдэнэхайрханд дээл өмсгөж, эсгий дэвссэн, Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Хүрэн дэлд хүнийхээ толгой дор нарийн ширхэгтэй даавуу дэрлүүлж, их бие доор нь эсгий дэвссэн зэрэг энэ бүс нутгаас хэд хэд илэрчээ. “...тухайн үеийн монголчууд нь бөмбөгөр оройтой, тойрсон хүрээтэй, ардаа шилэвч болон залаа бүхий малгайтай, нарийн ханцуй, урт хормойтой, голдуу зөв энгэртэй дээлийг биедээ өмсч, урт түрийтэй, яльгүй шовгор хоншоортой ширэн гутал өмсдөг байжээ...” (Баатар, Erdenebat 2010, 15) гэж хүн чулуу хөшөө, археологийн олдвор зэрэгт тулгуурлан тухайн цагийн монголчуудын хувцас хэрэглэлийг тодорхойлон гаргажээ.

Говийн бүсийн булшнаас ээмэг (хүрэл, сувдан) 12, зүүлт (чулуун, хув, сувс) болон бусад гоёл чимэглэл 40, хүрэл толь 12, богтаг малгай 10, дээл, бөс эдлэл 7, гутал 1 олджээ. Их өвгөн уулын 17-р булшнаас эмэгтэй, улаан өнгийн чулуу, сувдан сондор, хүрэл хослолтой, гоёлын зориулалттай хүрэл явуу, улаан өнгийн чулуун гоёл, зүрх хэлбэртэйгээр зассан, загалмай хэлбэртэй гоёлын чулуу, бөөрөнхий

цагаан чулуун зүүлт, мод, усны дүрстэй хээтэй хүрэл толь, торгон материал бүхий бүрэн бүтэн дээл зэрэг онцгой, ховор, баялаг олдвор гарсан байна. Мөн хүрэл толь, унжлагатай хүрэл сүүжин ээмэг, малгайн “ом” үсэгтэй хүрэл чимэглэл, толины уут бололтой ширэн уут олдсон байна. Эрт дундад үеийн нүүдэлчдийн оршуулгын зан үйлийн хүрээнд толь ёслолын чухал үүрэгтэй байжээ. Үхэгсдийнхээ булш оршуулганд толь хагалж дагуулах ёс Евразийн нүүдэлчин олон ард түмний оршуулах зан үйлд хэвшсэн нь тэдний сүнс ба нөгөө ертөнцийн тухай ойлголт төсөөлөлтэй нь нягт холбоотой байв. Дундад зууны монголчуудын хувьд булшинд хагархай юмуу эсвэл бүтэн толь хийх зан үйл байжээ. Археологийн судалгаанд толь бол дурсгалын он цаг тогтоох чухал туслах хэрэглэгдэхүүн болдог (Батдалай 2024, 141). Доктор У.Эрдэнэбат “Монгол булшнаас одоогоор илэрсэн бүх толийг хятадаас оруулж ирсэн жинхэнэ толь юм уу эсхүл импортын толины загвараар орон нутагт цутгасан хуулбар гэж үзжээ. Манай улсын нутаг дэвсгэрт малтсан монгол булшнаас илэрсэн толины дийлэнх нь Зүрчидийн Алтан улсын (1175-1234) үеийнх байгаа юм (Амартүвшин, Батзориг, Батдалай 2019, 132) хэмээн тэмдэглэсэн байдаг.

Говийн бүсийн Дундад зууны үеийн булшнаас *ахуйн шинжтэй эдлэлүүдэд* төмөр хайч, төмөр хутга, аяга, тэрэгний цөн зэргийг хамруулан үзэв. Төмөр хайч — Баруун шивээгийн ар, Цогтцэций–Ухаа худаг зэрэг газрын эмэгтэй хүний булшнаас олдсон бөгөөд ихэвчлэн толь, сам, сувс зэрэг гоёлын зүйлстэй хамт тавигджээ. Төмөр хутга нийт 12 ширхэг илэрсэн. Ихэнх нь модон иштэй, шовх үзүүртэй. Монгол булшинд хүйс харгалзалгүй тавьдаг хамгийн түгээмэл олдвор бол төмөр хутга хэмээн судлаачид тэмдэглэсэн байдаг. “Төмөр хутгыг оршуулганд дагалдуулан тавихдаа хүний гарын дагуу нүхний хана дагуулан үзүүрийг урагш харуулан тавьдаг. Мөн хутгыг булшинд бог малын далны хамт дээр нь тавьж дагалдуулах тохиолдол цөөнгүй тэмдэглэгдсэн байдаг” (Амартүвшин, Батзориг, Батдалай 2019, 132). Хүрэл болон шаазан аяга - Цагаан Хонд-1 булшнаас илэрсэн. Тэрэгний цөн энэ газар нутгийн нийт булшны гурваас илэрсэн байна. Оршуулах ёсны өөр нэгэн зан үйл бол сурвалжид тэмдэглэсэн “цогцос ачиж явсан тэрэг, гэрийг нь хамхчин хаяна” хэмээх мэдээнд (Батдалай 2024, 87) гардаг. Энд өгүүлсэнчлэн, тэрэгний цөн, гэрийн хана олдсон булш цөөнгүй. Булшинд аяга, ваарыг хамт тавих нь нас барагч нөгөө ертөнцөд хоол ундтай байх билэгдэлтэй байв. Энэ бүс нутагт тэрэгний цөн олдсон булш Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт “Оюу толгой” төслийн дэд бүтцийн талбайд Гавилууд багийн нутаг Хөх хадны бууцын орчимд Хөх хад-6 дугаартай дурсгалын дараас чулууны зүүн талаас 1, 2010-2011 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судалгааны анги Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших “Энержи Ресурс” ХХК-ийн “Ухаа худаг” нүүрсний уурхай орчимд малтсан 8 булшны хоёроос нь тэрэгний цөн илэрчээ.

Морины тоног хэрэгдэл. Монголчуудын хувьд эмээл нь зөвхөн уналгын хэрэгсэл төдий бус, тухайн хүний нийгмийн байр суурь, ёс заншил, сүнслэг итгэл үнэмшлийг илэрхийлдэг соёл, бэлгэдэл, зан үйлийн цогц зүйл байжээ. Монголчуудын эмээлийн уламжлал нь эртний нүүдэлчдийн соёлтой салшгүй холбоотой бөгөөд Хүннү, Түрэг, Уйгар зэрэг түрүү нүүдэлчдийн эмээлийн хийцийн уламжлал дээр суурилан хөгжжээ. Морины тоног хэрэгсэлд хамруулсан олдворыг цуглуулбал төмөр дөрөө хосоор болон өрөөсөн, эмээлийн хэсэг 2 ширхэг, амгай

1, хазаар 1 олджээ. Хамгийн тодорхой морин тоног хэрэгслийн иж бүрдэл нь Халивын голын савд илэрсэн булшнаас гарсан бөгөөд тэнд төмөр дөрөө, хазаарын амгай, хазаарын зуузай, төмөр арал зэрэг иж бүрэн хослол илэрсэн байна.

Хэлэлцүүлэг

Монгол булшны судалгаа сүүлийн жилүүдэд өргөжөхийн хэрээр судалгааны хүрээ ч тэлсээр байна. Үүнтэй уялдаад археологийн соёлын үүднээс судлах сонирхол мөн адил нэмэгдэж байна. Монгол булшны талаарх судлаачдын бүтээлүүд хэвлэгдэж байсан бөгөөд дагнан судалгаа хийдэг Х.Лхагвасүрэн (1994), У.Эрдэнэбат (2009), Б.Батдалай (2024) нар энэ чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалсан ба Х.Лхагвасүрэн, С.Хүрэлсүх, Ч.Амартүвшин, С.Өлзийбаяр нарын эрдэмтдийн бүтээлүүд хэвлэгдэн гарсаар байна. Харин хэсэгчлэн судалсан бичвэрүүд мөн хэвлэгдэж байжээ. Судлаач Т.Түвшинжаргал 2012 онд бог малын нуруу дагалдуулах зан үйл талаас, доктор У.Эрдэнэбат богтаг малгайн чимэглэл, Дундад зууны монголчуудын алтан эмээлийн тухай, судлаач Д.Сайхансүвд богтаг малгайн чимэглэлүүд, тэдгээрийн бэлгэдэл талаас, доктор Б.Мөнхцэцэг дээл, даавуун эдлэлийн нэхэн сэргээлт талаас зэрэг судалгаа хийж үр дүнг нийтлүүлж байсан байна.

Дүгнэлт

Улс үндэстний түүх, соёлыг судлахад археологийн олдвор маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол нутагт малтсан монголын үеийн булшны мэдээллийг газар нутгийн онцлогоос шалтгаалан найман ай саваар ангилж, Говийн бүсэд хамаарах булшны судлагдсан байдлыг тодруулан, олдворын зүйлсийг зан үйлд холбогдох олдвор, зэр зэвсгийн зүйлс, гоёл чимэглэл хувцас хэрэглэл, ахуйн хэрэглэл, морины тоног хэрэглэл гэсэн таван төрөлд ангилан авч үзлээ. Монгол нутагт малтан судалсан дундад зууны үеийн булш оршуулгын хэрэглэгдэхүүн 1960-аад оноос эхлэлтэй байгаа ч өнөө цагт бүрэн судлагдагдаагүй байна.

Эртний булш оршуулганд олдворыг тодорхой зан үйлийн дагуу тогтсон байршилд, тодорхой чиглэл харуулан байрлуулдаг ба эрэгтэй, эмэгтэй, хүүхдэд дагуулдаг олдвор мөн ялгаатай байжээ. Мөн нас хүйсээс шалтгаалан дагуулах эд юмсын тавилт, байршил, чиглэл ч өөрчлөгддөг байсан бололтой. Дагуулсан зүйлс тухайн хүний эдэлж хэрэглэж байсан зүйлс байхаас гадна тухай бүр нь бэлгэдэл агуулсан зан үйлийн холбогдолтой зүйлс байна. Энэхүү зан үйлийг тодруулан судалснаар эртний монголчуудын нийгэм, зан заншил, худалдаа, үйлдвэрлэл, оршуулгын соёлыг илүү нарийн тодорхойлох боломжтой болох юм.

Дээрх дурсгалууд нь Гурвантэс сумын нутаг дэвсгэрт XIII–XIV зууны үед оршин сууж байсан монголчуудын оршуулгын зан үйлийн тогтвортой уламжлал, мал аж ахуйд суурилсан ертөнцийг үзэх үзэл, нийгмийн бүтэц, соёлын харилцааны хүрээг цогцоор нь илтгэх чухал археологийн баримт болж байна. Эдгээр судалгааны дүн нь Өмнөговийн бүс нутгийн дундад зууны археологийн дурсгалын судалгаанд үнэт хувь нэмэр оруулж, Монголын эзэнт гүрний үеийн оршуулгын соёлын судалгааг баяжуулж байна.

Ашигласан материалын жагсаалт

- Амартүвшин, Ч., Гүнчинсүрэн, Б., Ерөөл-Эрдэнэ, Ч. ба бус. 2008. “Ухаа худагт хийсэн археологийн малтлага судалгааны үр дүн.” *Studia Archaeologica* Tomus XXVI: 213-234.
- Амартүвшин, Ч., Амгалантөгс, Ц., Галдан, Г., Жаргалан, Б. 2010. “Барууннаранд хийсэн археологийн малтлага судалгааны урьдчилсан үр дүн.” *Нүүдэлчдийн өв судлал* Том X: 28-56.
- Амартүвшин, Ч., Галдан, Г., Батдалай, Б., Бөхчулуун, Д. 2012. “Говийн бүсэд малтан шинжилсэн зарим монгол булшнууд.” *Studia Archaeologica* Том XXXII: 298-324.
- Амартүвшин Ч., Ишцэрэн Л., Бадма-Оюу Б. 2017. “Улаантолгойн хадны оршуулга (X-XI зуун).” *Studia Archaeologica* Том XXXVI: 271-280.
- Амартүвшин, Ч., Батзориг, О., Батдалай, Б. 2019. *Ханбогдын археологийн дурсгал. Улаанбаатар: “Хөх монгол принтинг” ХХК.*
- Батдалай, Б. 2024. “X-XVII зууны монгол булш, оршуулгын судалгаа (Монгол улсад малтсан хэрэглэгдэхүүнээр).” Ph.дисс., Монгол Улсын их сургууль.
- Волков, В.В. 1962. “Эртний монгол булш.” *БНМАУ-ын ШУА-ийн мэдээ* №4: 66-67.
- Өлзийбаяр С., Мөнхцэцэг О. 2025. “Монгол булшны судалгааны түүхийн үечлэл ба “дундад үеийн монголчуудын оршуулгын соёл” мэдээллийн сангийн үзэл баримтлал.” *Эзэнт гүрний үеийн монголчуудын үнэт зүйлс, соёл, сэтгэлгээг баримтаар мөшгөхүй*, Ер. ред. Алтанцэцэг Ч., Энхчимэг Ц., Золзаяа М.38-56. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Түвшинжаргал, Т. 2012. “Дундад эртний үеийн булшинд бог малын нуруу дагалдуулах зан үйлийг мөшгөх нь.” *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology* Vol 7. No.1 (378): 134-142.
- Түмэн, Д., Наваан, Д., Эрдэнэ, М. 2008. *South Gobi Sands компанийн Өмнөговь аймгийн Номгон сумын Цагаан толгойн ашиглалтын талбайд археологийн малтлага судалгаа хийсэн тайлан.* МУИС-ийн ААТ. ГБСХ.
- Түмэн, Д. 2010а. *Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Сүмбэр, Билүүтийн талбайд явуулсан археологийн хайгуул, малтлага судалгааны тайлан.* МУИС-ийн ААТ. ГБСХ.
- Эрдэнэбат, У. 2010. “Богтаг малгайн чимэглэл.” *Оюуны хэлхээ* 2010. I (06): 71-113.
- Эрдэнэбат, У. 2010. “Монгол булшны судалгаа.” *Studia Archaeologica (Дундговь аймагт хийсэн археологийн судалгаа: Бага Газрын чулуу)* Том (VII) XXVII: 260-264.
- Bayar Dovdoi, Erdenebat Ulambayar. 2010. “Mongolian Costums and Eurasian Culture.” *Хувцас загвар-өнгөрсөн одоо ирээдүй:* 14-22.